

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан .....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	19
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ДУЛААНЫ ТЕХНИК,  
ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЭКОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ  
Б.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

2020.02.27 № 06/638

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Дулаан техник үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Б.Жаргалсайхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн мөнгөн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулан мөрдөж ажиллах, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэн, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн “Дундманхайдай Аудит” ХХК-ийн захирал Ж.Бямбажав, аудитор Г.Цэдэнбалжир нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн 2019 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газар, “Дундманхайдай Аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 10 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн нь зорилгоо “Судалгааны ажлын үр дүнг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, шинжлэх ухааны ач холбогдлыг нийгэмд сурталчлан таниулах, техник технологийн шинэ шийдлийг нэвтрүүлэх, эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэл зэрэг зохимжтой хэлбэрийг оновчтойгоор хослуулан хөгжүүлэх, импортыг орлох брэнд бүтээгдэхүүн бий болгох” гэж тодорхойлсон.

Дээрх зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Дулаан-масс солилцооны ба шаталтын онол, дулаан хангамж, уурын ба усан халаалтын тогооны хийц технологи, эх орны буюу шинэ материал түүхий эдээр хийсэн бүтээгдэхүүний дулааны физикийн параметруудийг тодорхойлох, нарны энергийг дулаан хангамж, хөргөлтийн системд ашиглах;
- Эх орны эрчим хүчний үйлдвэрүүдийг зүүн хойд Азийн эрчим хүчний системд зохих байр суурьтайгаар, экологийн баримжаатай хөгжих гарцыг судлах;
- Шаталт, хий шингэний хөдөлгөөний математик загварчлал, оновчлол;
- Хот суурин, үйлдвэрийн экологийн карт зохиох, орон сууц, нийтийн аж ахуй, үйлдвэрийн хатуу хаягдлыг боловсруулан ашиглах технологи, үйлдвэрийн экологийн эдийн засгийн үнэлгээ, мөн энэ чиглэлээр арга зүй боловсруулах;
- Дээрх чиглэлээр дэлхийд бий болж байгаа шинжлэх ухаан техник, технологийн мэдээллийг судлах, сан байгуулах, чиг баримтлалыг холбогдох төр захиргааны байгууллагад өгөх, санал боловсруулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус хүрээлэн нь Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын яамны хэмжээнд мөрдөж байгаа 2017 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/40 дугаар сайдын тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна. Тус баримт бичиг Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байгаа ч тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцээгүй байна.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous”, “Payroll” программ хангамж ашигладаг байна.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 33 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны батлагдсан нийт зарлагын төсвийг сонгож, эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 288,523.4 мянган төгрөгөөс тооцон 5,770.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн шатанд дахин хянаж материаллаг байдлын түвшнийг тооцохдоо суурийг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал дээр урьдчилж гарсан зардлыг нэмж тодорхойлон 2 хувиар буюу 27,153.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,049,125.0 мянган төгрөгөөр буюу 55.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	35,683.4	132,571.1	96,887.7
Авлага	15,037.2	117,770.8	102,733.6
Урьдчилгаа	317,002.3	1,284,301.3	967,299.0
Бараа материал	72,961.3	71,982.4	(978.9)
Үндсэн хөрөнгө	1,449,152.7	1,332,336.3	(116,816.4)
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>1,889,836.9</b>	<b>2,938,961.9</b>	<b>1,049,125.0</b>
Өглөг	-	1,331.8	1,331.8
Урьдчилж орсон орлого	15,156.9	-	(15,156.9)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,874,680.0	2,937,630.1	1,062,950.0
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,889,836.9</b>	<b>2,938,961.9</b>	<b>1,049,125.0</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Авлага дансны үлдэгдэл 102,733.6 мянган төгрөгөөр өссөн нь тендерийн баталгааны төлбөр банканд байршуулсан байна. Авлага дансны эхний үлдэгдлийг тайлант хугацаанд барагдуулсан. Урьдчилж гарсан зардлын дансны үлдэгдэл 967,299.0 мянган төгрөгөөр өссөн нь тендерийн ажил гүйцэтгэхэд гарсан зардлыг хуримтлуулан тооцсон нь нөлөөлж байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь үйл ажиллагааны болон ашиглалтын зардлын гүйцэтгэлтэй холбоотой байна. Бараа материалын дансны



үлдэгдэлд 2017 онд худалдаж авсан ашиглалтгүй 2,000.0 мянган төгрөгийн ком сэлбэг материал байна. Энэ нь сэлбэг удаан хадгалснаас үнэ цэнээ алдах, үргүй зардал гарах нөхцөлийг бүрдүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансанд Шинжлэх ухаан технологи сэтгүүл 100 ширхгийг 729.0 мянган төгрөгөөр худалдан авсан бөгөөд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 116,816.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үед тооцсон элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 15,156.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны урьдчилж орсон орлогын үлдэгдэл тооцоог өмнөх оны хуримтлагдсан ашигт хааснаас шалтгаалсан байна. Өр төлбөр дансны үлдэгдэл нь 1,331.8 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,937,630.1 мянган төгрөг болж 1,062,950.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй. Гэвч тус хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэл статус, бүтэц, зохион байгуулалт тодорхой бус төсвөөс санхүүжилт авдаггүй, ТӨБЗГ-аар зорилтот түвшин батлуулаагүй байна. ШУТИС-ийн захирлаар 2019 оны орлого, зарлагын төлөвлөгөө батлуулсан нь бодит байдалтайгаа нийцээгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагч 2019 оны өөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулан 288,523.4 мянган төгрөгийн орлого, зарлагын төсвийг ШУТИС-ийн захирлаар батлуулсан байна. Тус төсөвт 40,700,0 мянган төгрөгийг тогтмол зардалд, 217,823.4 мянган төгрөгийг шууд бус зардалд, 30,000.0 мянган төгрөгийг эрдэм шинжилгээ инновацын үйл ажиллагааны зардалд тус тус зарцуулахаар батлагджээ.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн тайлант онд 288,523.4 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,438,193.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 498.5 хувиар биелүүлсэн байна. Орлого өмнөх оноос 666,066.5 мянган төгрөг буюу 86.3 хувиар өссөн нь Эрчим хүчний яамнаас зарласан тендерт шалгарсан ажлын санхүүжилтээр орлого нэмэгдсэнээс голлон шалтгаалсан байна.

Нийт зардлын 288,523.4 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 390,399.9 мянган төгрөгийг зарцуулсан нь дээрх баталсан зарлагын төсвөөс 101,876.9 мянган төгрөг буюу 35.3 хувиар илүү байна.

Цаашид үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлж шийдвэрлүүлэх, ТӨБЗГ-тай гэрээ байгуулж, зорилтот түвшин батлуулж ажиллах шаардлагатай байна.

Тус хүрээлэн нь улсын төсвөөс санхүүжилт авдаггүй, зорилтот түвшин батлуулаагүй орлого, зардлын гүйцэтгэл тайлагнаагүй хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг тодорхойлох боломжгүй байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 33 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 33 эрсдэл тодорхойлж нийт 33 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 408,588.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 384,797.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 15,236.6 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 5,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 3,553.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө. Үүнээс:



1 Тус хүрээлэн нь 1935 мкв талбай бүхий конторын зориулалттай барилгыг эзэмшдэг бөгөөд 925 мкв талбайг 1 жилийн хугацаатайгаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн харьяа Уул уурхайн хүрээлэнд түрээсэлж байна. Түрээсийн орлогын 30 хувь буюу 11,655.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнэ батлах тухай журам”-ын 1-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь ... түрээслүүлэх төлбөрийн хэмжээг түрээслэгчийн эрхэлж буй үйл ажиллагааны ангилал, салбарын чиглэлийг харгалзан дараах байдлаар тогтооно” “Бусад зориулалт-10,000.00 төгрөг” гэж заасантай тус тус нийцээгүй ба “ эрх ба үүрэг”, “тохиолдсон байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төвлөрүүлээгүй 11,655.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

2. Бусад этгээдээс худалдан авалт хийсэн үнээс ХХОАТ суутган тооцоогүй нь ХХОАТ-ын 23.1-т Энэ хуулийн 17 дугаар зүйл, 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна , Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасантай нийцээгүй, “Оршин байх”, Үнэн зөв байдал”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бусад этгээдээс худалдан авалт хийсэн үнээс ХХОАТ суутган тооцоогүй 3,581.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3. Иргэн, хуулийн этгээдтэй сарын 4.0 хувийн хүүтэй гэрээ байгуулж 155,500.0 мянган төгрөгийн санхүүгийн зээлийн өр төлбөр үүсгэсэн, зээлийн хүүд 5,000.0 мянган төгрөгийг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6.4.5-т "төсвийн захирагч төсвийн орлогыг барьцаалах, түүгээр баталгаа гаргахгүй байх;", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 6.6.2-т "төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;" гэсэн заалтуудтай нийцээгүй, “Тохиолдсон байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх, зээлийн өндөр хүү төлж үр ашиггүй зардал гаргахгүй байх, зээлийн өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлсэн.

4. Мөнгөн хөрөнгийн дансанд 12,500.0 мянган төгрөгийн зээлийн орлогын гүйлгээг буруу ангилан бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.-д "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

5. Худалдан авсан нүүрсний орлого, зарлагыг бараа материалын дансанд бүртгээгүй шууд зардлаар тайлагнасан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүрэн аккурэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.” гэснийг хэрэгжүүлээгүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

6. Шатахуун зарцуулалтын тайланг бараа материалын тайлангаас 161.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, байгууллагын хөрөнгөд бүртгэлгүй ажилтны хувийн автомашинд тушаал, шийдвэргүйгээр шатахууны талон олгож зарцуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

7. Өмнөх аудитаар тогтоосон 494.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудит хийх явцад төлбөрийн актыг барагдуулсан.

8. Тайлант хугацаанд гарсан 498.9 мянган төгрөгийн ажил гүйлгээг дутуу бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

9. Мөнгөн гүйлгээний тайланг шалгахад 38,000.0 мянган төгрөгийн өглөгийг буруу ангилан орлогын дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." гэсэн заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

10. Мөнгөн хөрөнгийн данснаас урьдчилж гарсан зардал 326,143.9 мянган төгрөгийн гүйлгээг шууд зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө." гэсэн заалттай нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулсан.

Аудитаар илэрсэн 3,553.9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Хөрөнгийн ангилал, ашиглалт, үнэлгээ, гэрээний үүргийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудыг аудитад хамруулж амжаагүй тул дараагийн аудитад хамруулан горим, сорил хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн дансанд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг "0" үлдэгдэлтэй болсон 505,395.1 мянган төгрөгийн анхны өртөгтэй 80 нэр төрлийн хөрөнгүүд байна.
2. Бараа материалын дансанд Зуухны хөгжлийн төвийн 70 м хашаа, 2 ш ном нийт 2,141.0 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.
3. Харилцагч байгууллагуудтай байгуулсан гэрээний биелэлт, гэрээг дүгнэж акт үйлдэж, үр дүнг тооцсон эсэхийг хамруулна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Тус хүрээлэн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, холбогдох мэдээллийг шилэн данс цахим хуудсанд байршуулаагүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 62,305,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 12,149.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоосныг барагдуулсан,

44,920.6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн, 5,235.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

#### **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

### 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Уул уурхайн хүрээлэнгийн ойд шагналд зориулан 500.0 мянган төгрөгийн бэлэн мөнгө зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Бэлэн мөнгийг зориулалт бусаар зарцуулах, үр өгөөж буурах;

3.1.3 Өгсөн зөвлөмж: Мөнгөн хөрөнгийг хэмнэлттэй үр ашигтай зарцуулах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

#### 3.2 НББ-ийн бодлоготой холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй, НББОУС, холбогдох заавар журамд нийцээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.2.2 Эрсдэл: Өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж мөрдөж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгээ байгууллагын онцлогт тохируулан боловсруулан мөрдөж ажиллах;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.3 Мөнгө хөрөнгийн данстай холбоотой асуудал**

- 3.3.1 Илрүүлэлт: Кассын тайлангийн бэлэн мөнгөний орлого зарлагын баримт дугаарлагдаагүй, дараа тайлан тооцооны 1,682.7 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баримт хангалтгүй, 12 дугаар сарын нярвын тайлан байхгүй кассын жилийн эцсийн үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 -д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;" гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн "Оршин байх", Үнэн зөв байдал", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.3.2 Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, мөнгөн хөрөнгийн тайлан гаргаагүй, ажил гүйлгээг бүртгэлд тусгаагүй байх;
- 3.3.3 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах;
- 3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

### **3.4 Хангамжийн данстай холбоотой асуудал**

- 3.4.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд 1,371.2 мянган төгрөгийн бараа материал, урсгал засварын материал, бусад хангамжийн материалыг анхан шатны бүрдэл дутуу баримтыг үндэслэн бүртгэлд тусгасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, санхүүгийн тайлангийн "Тохиолдсон байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.
- 3.4.2 Эрсдэл: Бараа материалын тайлангийн үлдэгдэл дүн буруу илэрхийлэгдэх;
- 3.4.3 Өгсөн зөвлөмж: Холбогдох хууль журмын дагуу анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах;
- 3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>440,684,226.13</u></b>	<b><u>1,606,625,539.73</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	35,683,433.13	132,571,090.31
<b>311</b>	<b>Кассад байгаа бэлэн мөнгө</b>	241,287.00	00.00
31130	Нэмэлт санхүүжилт	241,287.00	00.00
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	35,442,146.13	132,571,090.31
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	35,442,146.13	132,571,090.31
31217	Чингис хаан дахь харилцах		8000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	35,421,622.90	16,028,358.02
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	20,523.23	116,534,732.29
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	15,037,233.28	117,770,786.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,299,254.28	00.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	9,737,979.00	117,770,786.00
3351	Байгууллагаас авах авлага	9,737,979.00	117,770,786.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	317,002,300.00	1,284,301,275.00
34600	Урьдчилж гарсан зардал	317,002,300.00	1,284,301,275.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	72,961,259.72	71,982,388.42
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	72,961,259.72	71,982,388.42
35410	Бичиг хэргийн материал	517,000.00	00.00
35440	Түлш, шатах тослох материал	1,100,000.10	68.80
35470	Бусад хангамжийн материал	71,344,259.62	71,982,319.62
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,449,152,707.30</u></b>	<b><u>1,332,336,349.52</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,449,152,707.30	1,332,336,349.52
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,395,535,040.75	1,278,894,683.01
